

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2014 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ**


№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн талаарх мэдээлэл	Хувь
1	<p>Аймгийн иргэний танхимын хэлэлцэх асуудлын товыг мэдээллийн хэрэгсэлээр тогтмол мэдээлж олон нийтийн оролцоог хангах, саналыг авах</p>	<p align="center">Нэг.Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр</p> <p>Аймгийн ИТХ-ын Иргэний оролцооны хэлтэс нь тухайн жилд зохион байгуулах үйл ажиллагаагаа сар бүрээр календарчилж төлөвлөн хэрэгжүүлдэг юм. Иргэний танхимыг бэхжүүлэх чиглэлээр</p> <p>1. Соёмбо цогцолборт байрлах Иргэний танхимдаа сар бүрийн төлөвлөгөөтэй уялдуулж хэлэлцүүлэг зохион байгуулдаг бөгөөд хэлэлцүүлгийнхээ мэдээллийг долоо хоногийн өмнө интернет, Фэйсбүүк, орон нутгийн телевизээр сурталчилж иргэдэд мэдээлэл хүргэдэг. Иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор орон нутгийн телевизтэй гэрээ байгуулж ажилладаг.</p> <p>2. Иргэний оролцоог хангах чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн бус байгууллага болон сонирхлын бүлгүүдийг дэмжихолон төрөлт арга хэмжээг нийтэд ил тод зарлах, • 70520001 суурин утсаар....., • www.irgen.do.gov .mn сайтаар....., • Ioh.dornogobi@yahoo.com имэйл хаягаар • Иргэний үзэл бодлыг сонсох “Иргэний цаг” нэвтрүүлгээр • Хэлэлцүүлэг зохион байгуулах • Гар утасны “sms” үйлчилгээг нэвтрүүлж иргэдийн оролцоог ханган ажиллаж байна. Мэдээллийн сувгаар ирсэн иргэдтийн санал хүсэлт, өргөдөл гомдолд тухай бүр хариу мэдээлэл өгч ажилласан. 	
2	<p>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн болон Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг нээлттэй мэдээлж олон нийтийн саналыг шийдвэрт тусгах</p>	<p>Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг иргэдэд нээлттэй ил тод байлгах, иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах үүднээс Аймгийн Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүнд иргэд, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг оруулж, ажиллах журмыг шинэчлэн Аймгийн Засаг даргын 2014 оны А/524 дүгээр захирамжаар батлан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна /<i>захирамжийг хавсралтаар хүргүүлэв</i>/. Мөн Засаг даргын зөвлөлийн хуралдааныг нээлттэй явуулах үүднээс орон нутгийн телевизээр шууд нэвтрүүлэхээр бэлтгэл ажил хангагдаж байна.</p>	
3	<p>Аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг төрийн бус байгууллагатай хамтран олон</p>	<p>Авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөөг боловсруулах Иргэний нийгмийн байгууллагын төслийн ахлагч Э.Эрдэнэбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын даргатай хамтран</p>	

	<p>нийтийн оролцоотойгоор боловсруулах, хэрэгжилтийн явц, үр дүнг тооцох</p>	<p>ажиллах санамж бичигт гарын үсэг зурж төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааны явцад хамтран ажилласан.</p> <p>Аймгийн Авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөөг боловсруулахад төрийн бус байгууллага иргэдийн оролцоог хангах үүднээс 2014 оны 01 дүгээр сарын 13-26 ны өдрүүдэд хүн ам олноор төвлөрсөн Замын-Үүд сум, мөн төвлөрсөн суурин газраас алслагдсан Айраг, Хөвсгөл сумдыг сонгон “MercyCorps” Олон Улсын байгууллага, “Айсуй цагийн түүчээ” ИНБ-ын төлөөлөл болон Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн хамтран зохион байгуулж, зорилтод сумдын нийт 147 иргэн хэлэлцүүлэг арга хэмжээнд хамрагдсан байна. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан Сайншанд сумын иргэдийн дундах хэлэлцүүлэг хийгдээгүй бөгөөд төлөвлөгөөнд тусгах саналыг иргэдээс бичгээр авч тусгасан. Хэлэлцүүлгийн явцад оролцогч иргэдэд Авлигын эсрэг хууль тогтоомжийг танилцуулах, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, аймгийн 2013 оны авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулж, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Мөн хэлэлцүүлгийн үед зорилтод бүлгийн сумдын төрийн үйлчилгээний байгууллагуудаар орж үйл ажиллагаатай нь танилцан авлигаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг өгч ажилласан. /Ажлын хэсгийн мэдээлэл холбогдох материалыг хавсралтаар хүргүүлэв/.</p> <p>Авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2014 оны “Авлигаас урьдчилан сэргийлэх 2014 оны төлөвлөгөө батлах тухай” А/86 дугаар захирмжаар батлуулан АТГ-т мэдээллийг хуулийн хугацаанд хүргүүлсэн. /Төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлэв/</p> <p>Аймгийн нийт төрийн байгууллагын дарга нарын зөвлөгөөнд мэдээлэл хийх хуваарийн дагуу 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл өгч ажилласан. Орон нутгийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор вэб сайтыг шинэчлэн нийт 10.0 сая төгрөгийг зарцуулж, мэдээллийг тогтмолжуулах үүднээс аймгийн Засаг даргын орлогчоор батлуулсан “Цахим хуудасны мэдээллийн ил тод байдлыг хангаж аймгийн цахим хуудсанд мэдээлэл байршуулах төлөвлөгөө”-г батлуулан холбогдох хэлтэс тасагт хүргүүлж ажилласан. /Төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлэв/.</p>	
4	<p>Төрийн бүх шатны байгууллагад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчийн ёс зүйг сахиулах орон тооны бус зөвлөл байгуулж ажиллуулах, арга зүйгээр хангах</p>	<p>Авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2014 оны А/86 дугаар захирмжаар батлагдсан “Авлигаас урьдчилан сэргийлэх 2014 оны төлөвлөгөө батлах тухай”-д тусгаж нийт төрийн байгууллагуудад хүргүүлж, орон тооны бус зөвлөлийг иргэний нийгэм, төрийн бус байгууллагын оролцоог илүүтэй хангах чиглэлийг барьж ажиллах, мөн орон тооны бус зөвлөлийн ажиллах журам тодорхой байх чиглэлээр зөвлөмжийг өгч ажилласан. Сайншанд сумын Засаг даргын Тамгын газраас Орон тооны бус зөвлөлийг байгуулан ажиллуулж байна. Бусад байгууллагууд байгууллагын дэргэдэх ёс зүйн</p>	

		хороогоороо дамжуулан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчийн ёс зүйтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна. Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл ирээгүй байна.	
5	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийн явц, үр дүнг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр олон нийтэд сурталчлах</p>	<p>Авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үүднээс төрийн нийт байгууллагад албан тоотоор хүргүүлж, иргэдэд мэдээлэл болгон “Дорноговийн шуудан” хэвлэлд нийтлүүлэн орон нутгийн 300 иргэнд үнэ төлбөргүй тараасан. /2014 оны 03.03-ны өдрийн №26 (027) хэвлэлийг хавсралтаар хүргүүлэв/.</p> <p>Мөн Авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, 2013 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг иргэдэд хүргэх зорилгоор орон нутгийн DSB телевизээр Хууль зүйн хэлтэс, “Айсуй цагийн түүхээ” ИНБ, “MercyCorps” ОУБ-ын төлөөлөл оролцсон 30 минутын нэвтрүүлгийг нээлттэй утас ажиллуулан иргэдийн асуултад шууд хариулах замаар зохион байгуулж явуулсан.</p> <p>Авлигаас урьдчилан сэргийлэх 2014 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг “Дорноговийн шуудан” хэвлэлд нийтлүүлэхээр бүрэн эхээр өрөлтөд оруулаад байна. Хэвлэл 2014 оны 12 дугаар сарын 09-ны өдөр Олон улсын буюу Авлигын эсрэг өдрөөр иргэдэд тараагдахаар хэвлэлийн эх бэлтгэгдэж байна.</p>	
6	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны 2013 оны үнэлгээний үр дүнгийн талаарх мэдээллийг сум, агентлагуудад хүргэх, санал зөвлөмжийг хэрэгжүүлэх.</p>	<p>2014 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр сумдын Засаг дарга нарын нэгдсэн семинарыг зохион байгуулах хөтөлбөрийн дагуу Хууль зүйн хэлтээс дараах зөвлөмжийг хүргүүлсэн.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Авлигатай тэмцэх газраас Монгол улсын их хурлын гишүүн, Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг даргад 2014 оны 03 дугаар сарын 31-ны өдөр хүргүүлсэн Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8-д заасны дагуу зарим аймгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын танилцуулгыг 01/2453 албан тоотоор хүргүүлсэнийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийг ХЭГ/634 тоотоор аймгийн Засаг даргад ирүүлсэн тул холбогдох мэдээллийг нийт сумдын Засаг дарга нарт танилцуулсан. Аймгийн хэмжээнд 12 сум 90 жилийн ойн арга хэмжээ зохион байгуулахтай холбогдуулан хандивын ямар нэгэн арга хэмжээ зохион байгуулах, санаачлахгүй байхыг хатуу анхааруулж, танилцуулгыг хувиалан хүргүүлсэн. Аймгийн 2013 оны төлөвлөгөөний хэрэгжилт болон 2014 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах асуулт хариулт зохион байгуулж, өөрийн байгууллагын авлигын эсрэг төлөвлөгөөний гүйцэтгэлийг сайжруулах зөвлөмж өгсөн. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 03/7007 тоот зөвлөмжийн дагуу аймгийн Засаг даргаас 14 сумын Засаг дарга, 15 байгууллагын дарга нарт зөвлөмжийг хүргүүлсэн. /тоотыг хавсралтаар хүргүүлэв/. Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Боловсролын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар, Тээвэр авто замын газар, Байгаль орчны газар гэх мэт 10 байгууллагын үйл ажиллагаанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил 	

		<p>тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан шалгах хуудсын дагуу шалгалтыг 2014 оны 09 дүгээр сарын 18,19-ны өдрүүдэд шалгаж холбогдох байгууллагын дарга, эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг чиглэл өгч ажилласан. Шалгалтын явцад Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар сэлгэн ажиллуулахдаа АТГ-ын дүгнэлт гаргуулаагүй 6 албан хаагч,Тээвэр авто замын газар шинээр томилогдон ажиллаж буй авто тээврийн хяналтын улсын байцаагч -3,Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн -1,Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс-4 албан хаагч, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар-1 албан хаагч АТГ-ын дүгнэлтгүй томилогдсон байсан шийдвэрийг хүчингүй болгуулж зөрчлийг арилгаж ажиллах үүрэг чиглэл өгч мэдээллийг АТГ-г хүргүүлсэн. /Албан тоот, шалгалтын хуудсыг хавсралтаар хүргүүлэв/.</p>	
7	<p>“Монгол улсад үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, авлигатай тэмцэх” Үндэсний хөтөлбөр/2014 онд батлагдах/-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Монгол улсад үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр дээд шатны байгууллагаас батлагдаж ирээгүй тул хэрэгжилт гаргах боломжгүй байна.</p>	
8	<p>Авлигын эсрэг арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг аймаг, сумдын төсөвт тусган зарцуулах</p>	<p>Авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2014 оны “Авлигаас урьдчилан сэргийлэх 2014 оны төлөвлөгөө батлах тухай” А/86 дугаар захирмжаар 6900,0 төгрөгийг зарцуулахаар тусгаж, иргэдэд мэдээлэл хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, орон нутагт ажиллаж буй эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, болон бусад сургалтанд нийт 17,0 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан говийн бүсийн сургалтанд оролцогчдод зориулсан аймгийн мэдээллийн “Дорноговийн мэдээлэл” хэвлэмэл материалыг 120,0 мянган төгрөгөөр хэвлүүлэн тараасан байна.</p>	
9	<p>Авлигын эсрэг тодорхой асуудлаар уриалга, мэдэгдэл, амлалт Төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран гаргах, “Авлига, хүнд сурталгүй аймаг” болох санаачилгыг олон нийтэд мэдээлэх</p>	<p>Олон улсын Авлигын эсрэг өдрийг тохиолдуулан “Авлига, хүнд сурталгүй аймаг” уриалгыг гаргаж дуу хоолойгоо нэгтгэн ажиллахаар хууль сахиулах байгууллагын /аймгийн Шүүхийн тамгын газрын дарга, аймгийн Прокурорын орлогч, Цагдаагийн газрын дарга, Дорноговь аймаг дахь Тагнуулын хэлтсийн дарга, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, 2-р тойргийн Тахарын албаны дарга, Шүүхийн шинжилгээний алба, Хилийн цэргийн 0129-р ангийн төлөөлөл/ оролцсон 2014 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн уулзалт арга хэмжээний явцад зөвлөлдөж шийдвэрлэсэн. /Хугацаа болоогүй тул үнэлэх боломжгүй байна/.</p>	
10	<p>Аймгийн Засаг дарга, харьяа хэлтэс, газрын дарга нар шударга, ил тод, авлига, хүнд сурталгүй ажиллах, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлээ төрийн албан хаагчид болон олон нийтэд илэрхийлэх</p>	<p>Олон улсын Авлигын эсрэг өдөр буюу 2014 оны 12 дугаар сарын 09-ны өдөр нийт төрийн байгууллагуудын удирдлага орон даяар шударга, ил тод, авлига, хүнд сурталгүй ажиллах, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлээ илэрхийлж цахим хуудсаар нэгэн зэрэг /нэг цаг хугацаанд/ өөрсдийн хүсэл эрмэлзлээ илэрхийлсэн уриалга гаргаж, байгууллагынхаа төрийн албан хаагч болон олон нийтэд илэрхийлэхээр нэгдсэн зохион байгуулалтад орсон. 2014 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн энэхүү арга хэмжээг www.dornogovi.gov.mn цахим</p>	

		хаяг, орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхээр ажиллаж байна. /Хугацаа болоогүй тул үнэлэх боломжгүй байна/.	
11	Авлигын эсрэг 2013 оны сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, нэвтрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах	“ <i>MersyCorps</i> ” ОУБ-ын төлөөлөгчийн газарт сайн туршлагын талаарх мэдээллийг албан тоотоор хүргүүлж олон нийтэд сурталчилах материалд тусгуулсан. Мөн өөрийн байгууллагын www.dornogovi.gov.mn хуучин цахим хаягт байршуулсан нийтэд түгээсэн.	
12	Төрийн албан хаагчдын ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, энэ талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй байлгах	Аймгийн хэмжээнд төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, хэлтэс, алба, нэгж болон түүнд ажиллаж байгаа албан хаагчдын ажлын чиг үүргийг нийтэд ил тод байлгах үүднээс хаягжуулалт хийх, байгууллагын бүтэц, орон тоо, албан хаагчдын чиг үүргийг аймгийн албан ёсны цахим хаяганд байршуулах ажлууд хийгдсэн. “Том төрөөс ухаалаг төр лүү” Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 52/32 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг Хууль стандартын хэлтэс, Судалгаа, стратеги, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэлтэс гэсэн үндсэн нэгжүүдтэй байх саналыг батлуулахаар Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн. Энэхүү загвар бүтцийг батлагдсан тохиолдолд сумдад хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	
13	Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, тусгайлсан дүрэмгүй төрийн байгууллагуудын албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлэх.	Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйндүрмийг мөрдөн ажиллаж байгаа ба тус дүрмийг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2013 оны А/28 дугаар тушаалаар “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам” болон төрийн байгууллагын үйл ажиллагаа, иргэд, олон нийтэд үзүүлэх “Үйлчилээний стандарт”-ыг батлан аймгийн хэмжээнд мөрдүүлэн ажиллаж байна. Сумдын Засаг даргын Тамгын газар болон тусгайлсан дүрэмгүй төрийн зарим байгууллагуудын албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинээр батлан мөрдөж байна.	
14	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах, олон нийтэд нээлттэй байлгах.	2014 онд шинээр ажилд томилогдохоор нэр дэвшсэн 31 иргэний ХАСУМ-ыг цахим дрограмд хуулийн хугацаанд оруулж, 30 албан хаагчийн ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргуулсан. 1 албан хаагч ажиллахаас татгалзсан байна. Зөрчлийн мэдэгдэл тайлбарыг 2014 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн байдлаар 240 албан хаагчаас гаргуулж цахим програмд оруулсан.	
15	Эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрүүд авлига, хүнд суртал үүсэх боломж бүрдүүлсэн эсэхийг хянан үзэх, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох, өөрчлөх саналыг	Дорноговь аймгийн 14 сумын Засаг дарга нараас батлан гаргасан 350 орчим захирамжийн эрх зүйн үндэслэл, агуулга, стандартад хяналт шалгалтыг хийж ажилласан. Хяналт шалгалтаар энэ төрлийн зөрчил илрээгүй байна. Мөн доорх мэдээлэл бүхий наалтыг төрийн байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдын үүдэнд байнга байрлуулан иргэдээс тухайн байгууллагад үүсч буй хүнд суртал, авлига, гомдол мэдээллийг шууд хүлээн авч ажиллаж байна.	

<p>холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх.</p>	<div style="border: 2px solid red; padding: 10px; text-align: center;">  <p>“ТОМ ТӨРӨӨС УХААЛАГ ТӨР ЛҮҮ” </p> <p>Аймгийн Засаг даргын тамгын газраас Иргэдийнхээ санал хүсэлтийг хүлээн авах цахим систем нэвтрүүлээ.</p> <p>Иргэд та бүхэн www.70520003.mn өргөдөл гомдол хүлээж авах, түүний шийдвэрлэлтэнд хяналт тавих цахим систем рүү хандах болон 70520003 утсаар санал хүсэлт өргөдөл гомдлоо ирүүлнэ үү .</p> <p>ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</p> </div>	
<p>16 Төрийн байгууллага, албан тушаалтны авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шийдвэрийг АТГ болон Хууль зүйн яаманд чиглэлийн дагуу дахин нягталж хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах.</p>	<p>Төрийн байгууллагад албан ёсоор ажилладаг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хувьд ашиг сонирхлын зөрчил үүсэх, төрийн болон бусад чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрөөр ашиглагдаж байгаа зарим багаж тоног төхөөрөмжийг хувийн хэвшилдээ ашиглах өвчтөнийг өөрийн хувийн эмнэлэгтээ үйлчлүүлэхээр нөлөөлөх үйлдэл гаргаж байх магадлалтай гэсэн үүднээс төр хувийн хэвшлийн холилдсон замбараагүй байдлыг таслан зогсоох нь зүйтэй гэж үзэж холбогдох мэдээллийг АТГ-ын даргад хүргүүлсэн хэдий ч хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж мэдээлэл ирүүлээгүй байна.</p> <p>Авлига хүнд суртал үүсэх, нөхцөл боломж бүрдсэн шийдвэрийг төрийн байгууллагуудаас гараагүй.</p>	
<p>17 Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудад авлига байгаа эсэх, үүсч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох санал асуулга иргэдийн дунд явуулах, санал асуулгын дүнг аймгийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийтэд мэдээлж сурталчлах</p>	<p>“Азийн сан”, “MersyCorps” ОУБ-аас гаргасан авлигын талаар хийсэн судалгааг хэвлэмэл байдлаар хүлээн авч аймгийн Засаг даргын Тамгын газрын “Нэг цонхны үйлчилгээ”, мэдээллийн самбарт байршуулж иргэдэд мэдээлэл хүргэсэн. Мөн агентлагийн дарга нарын 14 хоногт зохион байгуулдаг хуралдаанд танилцуулсан.</p>	
<p>18 Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргаж, уг ажил, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагаа хууль тогтоомж, холбогдох дүрэм, журамд нийцэж буй эсэхийг хянах</p>	<p>Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг хавсралтаар хүргүүлэв.</p>	

19	Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдэгээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг байрлуулахгүй байх	Төрийн байгууллагуудад албан ёсны шаардлагыг 2013 оны 05 дугаар сараас эхлэн тавьж үйлчилгээ үзүүлж, орлого олдог нөхцөл байдлыг 100 хувь таслан зогсоосон.
Хоёр. Соён гэгээрүүлэх чиглэлээр		
20	ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад авлигын тухай ойлголт мэдлэг олгох	Боловсролын газартай хамтран 2014 оны 12 дугаар сарын 09-ны өдөр ахлах ангийн сурагчдын дунд мэдлэг дээшлүүлэх сургалт, АХА тэмцээнийг зохион байгуулахаар төлөвлөсөн. Хүүхэд гэр бүл, хөгжлийн хэлтсээс Хүүхдийн өөрөө удирдах байгууллагын гишүүн 20 хүүхдэд Авлигын талаарх ерөнхий ойлголт олгох сургалтыг 1 удаа зохион байгуулж, 30 ширхэг зурагт хуудас тараасан.
21	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, хамтран ажиллах	Авлигаас ангид шударга нийгмийг цогцлоон бүрдүүлэх зорилгоор 2013-2014 онд “MercyCorps” ОУБ, “Айсуй цагийн түүчээ” ИНБ болон ҮЭХ-той хамтран ажиллаж ирлээ. ИНБ-аас Сайншанд, Замын-Үүд, Хөвсгөл, Айраг сумдад Авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөөг боловсруулахад хамтран ажилласан бол Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай сумдын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт хийх судалгааг 2000 гаруй хүнээс авч судалгааг нэгтгэх шатандаа байна.
22	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилгыг дэмжих	Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлсэн “Том төрөөс ухаалаг төрлүү” санаачлагыг дэмжиж аймгийн Засаг даргаас нийт төрийн байгууллага, төрийн бус байгууллагын нийт 7500 иргэнд төрийн үйлчилгээний стандарт, үйлчилгээний шинэ шатанд хэрхэн хүрэх талаарх лекцыг уншлаа. Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн гаргасан саналын дагуу тус байгууллагын 2014 оны төлөвлөгөөг боловсруулахад 147 иргэний саналыг авч тусгасан байна.
23	Авлигын эсрэг, ашиг сонирхолын тухай хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор телевизийн цуврал хичээл, эрх зүйн зөвлөгөө, шторк бэлтгэн нийтэд түгээх	Авлигын эсрэг хуулийн сургалт арга хэмжээг орон нутгийн хэмжээнд давхардсан тоогоор 24 удаа зохион байгуулж 8600 гаруй иргэн, албан тушаалтанд зохион байгуулж 13 төрлийн гарын авлага материалыг 9.0 ширхэгийг тараасан байна. Аймгийн төв талбайн дэлгэцээр Төлөөс теле жүжгийг өдөрт 3 удаагийн давтамжтай 8 удаа томоохон арга хэмжээний үеэр иргэдэд үзүүлсэн байна. Олон улсын Авлигын эсрэг өдрийг угтан мэргэжлийн уран бүтээлчдээр Авлигын эсрэг хууль, НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн дагуу жүжигчилсэн тоглолт хийлгэхээр зохиолын эх бэлтгэгдэж байна.
24	Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг төрийн албан хаагчдад судлуулах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх бусад арга хэмжээг зохион байгуулах	Аймгийн Засаг даргын Тамгын газраас АТГ-ын www.meduuleg.mn цахим хуудасны дүрэм журам гэсэн цонхноос холбогдох гарын авлагыг татан авч байгууллагын албан хаагчдад судлуулж байна. Мөн НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн хориглолт хязгаарлалтаар төсвийн байгууллагын нягтлан бодогч нарт сургалт зохион байгуулж 32 албан хаагчийг хамруулсан. Авлигын эсрэг хуулийн сургалт арга хэмжээг орон нутгийн хэмжээнд давхардсан тоогоор 24 удаа зохион байгуулж 8600 гаруй иргэн, албан тушаалтанд зохион байгуулж 13 төрлийн гарын авлага материалыг 9.0 ширхэгийг тараасан байна.
25	Төрийн зарим байгууллагуудын авлигын эсрэг зохион байгуулж буй	Сайншанд сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, мэдээллийг иргэдэд шууд хүргэх зорилгоор зохион байгуулж буй “Хамтын

	ажил, арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцаж, арга зүйн зөвлөгөө, ажлын чиглэл, зөвлөмж өгөх	Санал-Хотын хөгжил-333” уулзалт арга хэмжээ, “Өртөөчилсөн төрийн үйлчилгээ”, Сайншандын мэдээ хэвлэмэл хуудас, Хөдөлмөрийн хэлтсийн мэдээллийн ил тод байдлын самбар зэрэг нь илүү амьдралд ойр, иргэдэд хүртээмжтэй арга хэмжээ болсон. Зарим сумдын Засаг даргын Тамгын газраас Авлигын эсрэг амлалтын дэвтэрт албан хаагчдын хүсэлтээр гарын үсэг зуруулах, шинээр томилогдон ажиллаж буй албан хаагчдад байгууллагын дотоод журам үйл ажиллагаанд мөрдлөгө болгон ажилладаг хууль тогтоомжийг таниулж гарын эсэг зуруулах үйл ажиллагаа тогтмолжсон. Мөн Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр хүргүүлсэн албан тоотыг аймгийн Засаг даргын албан тоотоор 14 сум, нийт төрийн байгууллагад хүргүүлж хэрэгжилтийг хянан ажиллаж байна. Хяналт шалгалтын хуудас болон аймгийн Засаг даргын захирамжийг хавсралтаар хүргүүлэв.	
26	Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг албан хаагч бүрт танилцуулах, үйл ажиллагаанд чанд мөрдүүлэх	Төрийн захиргааны албанд анх орох иргэдийн мэргэшлийн шалгалт өгч тэнцэн төрийн захиргааны албанд томилогдон ажиллаж байгаа албан хаагчид Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөхөд төрийн захиргааны албан хаагчийн тангаргийн хуудасны хамт төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйлийг тусгасан хэвлэмэл хуудас хавсарган өгч танилцуулан хадгалуулдаг. Мөн байгууллага бүр шинээр томилогдон ажиллаж байгаа албан хаагчдад байгууллагын дотоод журам, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн үйлчилгээний стандарт болон бусад холбогдох дүрэм журмыг албан ёсоор танилцуулж хэвшсэн. Төрийн албан хаагчдад ёс зүйн сургалт 8 удаа зохион байгуулж 120 гаруй албан хаагчийг хамруулсан. Ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдсон 3 төрийн албан хаагчдад зохих сахилгын шийтгэлийг ногдуулан ажиллаж байна.	
27	Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхэд байгууллагын удирдлагаас тавих хяналтыг өндөржүүлэх	Аймгийн Засаг даргын Тамгын газар болон харьяа агентлагийн дарга, эрхлэгч нарын дунд 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдөр шуурхай хуралдаан зарлаж байгууллагын дарга эрхлэгч нараас гарч буй эрх зүйн акт гаргах, төсөл боловсруулах, гэрээ байгуулахад хувийн ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг хангалтгүй гаргаж байгааг мэдээллээд мэдэгдэл тайлбарыг хэрхэн гаргах, ямар тохиолдолд гаргах талаар сургалт, ярилцлага зохион байгуулж хяналтаа сайжруулж ажиллахыг үүрэг болгосон. Сургалт ярилцлаганд төсөвт байгууллагын 13 дарга, эрхлэгч нар хамрагдсан.	
28	Төрийн албан хаагч эрхэлсэн албан тушаал, ажлын байрны тодорхойлолтод заасан мэдлэг чадвартай эсэх, ёс зүй, харилцаа хандлага хамт олон, үйлчлүүлэгчдийн дунд нэр хүнд ямар байгаа талаар судалгаа хийж, судалгааны дүнгээр шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Аймгийн хэмжээнд сум бүрийн нийт иргэдийн 0.5 хувьтай тэнцэх тооны иргэдээс төрийн үйлчилгээний өнөөгийн байдал, үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдын мэдлэг чадвар, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, төрийн үйлчилгээ авсан иргэдийн сэтгэл ханамжийн талаар судалгааг аймгийн ҮЭХ-той хамтран ажиллах гэрээ байгуулан 2014 оны 10 дугаар сард зохион байгуулж судалгааны дүнг нэгтгэж байна. Энэхүү судалгааны дүнг 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулах сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга болон холбогдох албан тушаалтан, зарим агентлаг, төсвийн байгууллагын дарга эрхлэгч нарыг оролцуулсан “Хэрэгжилт-хяналт-хариуцлага” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг, зөвлөгөөнөөр	

		<p>танилцуулж хариуцлагагүй ажилласан төрийн албан хаагчдад хариуцлага тооцож, анхаарвал зохих асуудал, зөрчил дутагдлыг залруулах арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөсөн.</p> <p>Мөн Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн эдийн засаг нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу нийтийн албан хаагчийн мэдлэг чадвар, ёс зүй, харьцаа хандлагыг үйлчлүүлэгч иргэдээр үнэлүүлэх журмын төслийг боловсруулж батлагдах шатандаа явж байна. Журамд тусгагдсанаар төрийн үйлчилгээ авсан иргэдээс үйлчилгээ үзүүлсэн албан хаагчид өгсөн үнэлгээг нэгтгэн тухайн төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж дүгнэхэд шалгуур үзүүлэлт болгон тусгаж үр дүнг харгалзан урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээг авч ажиллах, албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилготой төлөвлөсөн.</p>
		Гурав. Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр
29	<p>Хууль тогтоомж, дүрэм, журам шаардлагатай маягт болон зөвшөөрлийн бүртгэл бусад мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулах.</p>	<p>Аймгийн цахим хаягын ашиглалтыг нэмэгдүүлэх, стандартыг хангах үүднээс вэб сайтыг шинэчлэн зарим байгууллагын цахим хаягын холболтыг хийж байна. Шаардлагатай мэдээллийг аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс тасгуудаас тухай бүр шинэчлэн хийж вэб сайтын үйл ажиллагааг сайжруулсан 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 102,5 мянган зочин мэдээлэл авсан байна. Хууль тогтоомж, дүрэм, журам шаардлагатай маягт болон зөвшөөрлийн бүртгэл бусад мэдээллийг тухай бүр www.dornogovi.gov.mn цахим хуудасны Хууль эрх зүйн булангийн тусгай зөвшөөрөл хэсгээс үзэх боломжтой.</p>
30	<p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, шийдвэрийн төслийг цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтийн саналыг тусгах боломжийг бүрдүүлэх</p>	<p>Аймгийн Засаг даргын 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/530 тоот захирамжаар аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас батлан гаргах шийдвэр, бодлогын баримт бичиг боловсруулах болон зохион байгуулж байгаа арга хэмжээнд сонирхсон иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах журмыг баталсан. /Холбогдох материалыг хавсралтаар хүргүүлэв/. Дээрх журмаар шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, шийдвэрийн төслийг цахим хуудаст байршуулах, аймгийн Засаг даргын захирамжийн санал авах хуудсанд сонирхсон иргэд, иргэний нийгмийн байгууллагын саналыг авах, оролцоог хангах боломж бүрдээд байна. Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт гаргахад цахим хаягт 30 хоногийн турш байршуулж байна. Архигүй Дорноговь дэд хөтөлбөр боловсруулж эхийг сайтад 3 сарын турш байршуулж иргэдээс санал асуулга авсан.</p>
31	<p>Эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй шийдвэр /захирамж, тушаал/-ийг ил тод нээлттэй байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлэх /мэдээллийн самбар, цахим хуудас/</p>	<p>Аймгийн Засаг дарга, Тамгын газрын даргын хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд гарч байгаа захирамж, тушаалыг нийтэд ил тод байлгах үүднээс аймгийн цахим хуудсанд тухай бүр байршуулж байгаа ба тухайн шийдвэрийн зүүн доод хэсэгт захирамж, тушаалыг гаргасан албан тушаалтны нэр, гар утсыг бичиж Иргэний танхим, аймийн Нийтийн номын санд хувилан байршуулж иргэдийн танилцах нөхцөл боломжийг хангаж ажиллаж байна. Шинээр гарсан тушаал шийдвэрийг тухай бүр нэмэлт хийж байгаа бөгөөд холбогдох албан тушаалтанд хариуцуулсан.</p>

32	<p>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам зааврыг нээлттэй болгох</p>	<p>Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжууд бүх нийтэд ил тод нээлттэй байдаг ба орон нутгийн хэмжээнд мөрдөгдөх аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргын шийдвэрээр батлагдах дүрэм, журмыг хуулийн хугацаанд иргэдэд нээлттэй байдлаар хэлэлцүүлэн гарсан саналыг тусгах, батлагдсан тухай бүрт нь аймгийн цахим хуудсанд болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулах, сонирхсон этгээдэд тайлбарлан таниулах ажлууд хийгдэж байна. Жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн албан хаагчийн үйлчилгээний стандарт, • Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээний шинэ менежмент нэвтрүүлж аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам, • Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас батлан гаргах шийдвэр, бодлогын баримт бичиг боловсруулах болон зохион байгуулж байгаа арга хэмжээнд сонирхсон иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах журам • Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журам, • Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллагууд болон сумдын нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үр дүнг үнэлж дүгнэх журмыг цахим хаяг, мэдээллийн самбар, Иргэний танхим, Нийтийн номын сангаар нээлттэй байршуулан сурталчилсан. 	
33	<p>Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг ил тод болгох</p>	<p>Аймгийн Засаг даргын 2014 оны А/35 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Зорилтын хүрээнд:</p> <p>Албан хаагчдыг хөгжүүлэх чиглэлээр мэргэшүүлэх болон зорилтот, богино хугацааны сургалтуудад хамруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн боловсрол, соёлыг төлөвшүүлэх, байгууллагын дотоод хяналт, хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хяналт тавьж, нийтийн албан хаагчийн мэдлэг чадвар, ёс зүй, харьцаа хандлагыг үйлчлүүлэгч иргэдээр үнэлүүлэх журмын төслийг боловсруулж батлуулахаар ажиллаж байна.</p> <p>Байгууллагын үйл ажиллагааг ил тод, тунгалаг болгох зорилтын хүрээнд Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас батлан гаргах шийдвэр, бодлогын баримт бичиг боловсруулах болон зохион байгуулж байгаа арга хэмжээнд сонирхсон иргэд, иргэний нийгмийн байгууллагыг оролцуулах журам батлаж, орон нутгийн фм, телевизүүдтэй гэрээ байгуулж, аймгийн цахим хуудсыг шинэчлэн зайлшгүй байх шаардлагатай мэдээ мэдээлэл, цаг үеийн зохион байгуулсан арга хэмжээний мэдээллийг нийтэд мэдээлж байна.</p>	
34	<p>Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх</p>	<p>www.dornogovi.gov.mn аймгийн вэб сайтад нээлттэй байршуулсан.</p>	

	зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг ил тод болгох	
35	Байгууллагын албан ёсны цахим хуудсанд зайлшгүй байх мэдээллийн жагсаалтын дагуу мэдээллийг бүрэн оруулж, тухай бүр шинэчилж байх	Дорноговь аймгийн www.dornogovi.gov.mn вэб сайтад орон нутгийн болон бусад үйл явдлын талаарх мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулж вэб хуудасны архивт нийт ... мэдээг байршуулаад байна. www.dornogovi.gov.mn вэб сайтын мэдээ мэдээлэл цонхны үйл явдлын мэдээ, видео мэдээ, фото мэдээллээс үзэх боломжтой.
36	Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалт, сул орон тооны болон нөөцөөс нөхөх зарыг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийтэд тухай бүр мэдээлэх	Дорноговь аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 2014 онд төрийн албанд анх орох иргэдийн мэргэшлийн шалгалтыг 1 удаа, төрийн жинхэнэ болон үйлчилгээний албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 3 удаа зохион байгуулсан. Сул орон тооны зарыг тухай бүр шалгалт зохион байгуулахаас 21 хоногийн өмнө төрийн албаны зөвлөлийн болон аймгийн албан ёсны цахим хуудсаар мэдээллэхээс гадна орон нутгийн РМ, телевизүүдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр шалгалтын зарыг олон нийтэд мэдээллэдэг.
37	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Төрийн албаны мэргэшлийн болон Удирдах ажилтны сонгон шалгаруулалтуудыг цахим системээр зохион байгуулдаг болж шалгалтын явц, үр дүн, нөөцийн бүртгэл зэрэг нь олон нийтэд ил тод байршиж хяналт тавих боломжтой болсон. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газар, агентлаг байгууллага, сумдын нутгийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоог аймгийн цахим хуудсанд иргэдэд ойлгомжтой байдлаар байршуулах ажил шат дараатайгаар хийгдэж байгаа бөгөөд сул орон тооны захиалгыг төрийн албаны зөвлөлийн болон аймгийн албан ёсны цахим хуудас, орон нутгийн фм, телевизүүд, утсаар мэдээлж байна.
38	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэн зөв, шударга үнэлэх үүднээс аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд “албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн, ёс зүй, харьцаа хандлагыг үнэлэхдээ үйлчлүүлэгчдийн үнэлгээг гол шалгуур болгодог журам батлуулах” хэмээн тусгаж 2014 онд “Нийтийн албан хаагчийн мэдлэг чадвар, ёс зүй, харьцаа хандлагыг үйлчлүүлэгч иргэдээр үнэлүүлэх журам”-ын төслийг боловсруулан, батлуулахаар ажиллаж байна. Журмын төсөлд төрийн үйлчилгээ авсан иргэдээс үйлчилгээ үзүүлсэн албан хаагчид өгсөн үнэлгээг нэгтгэн тухайн төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж дүгнэхэд гол шалгуур үзүүлэлт болгон тусгаж үр дүнг харгалзан урамшуулах, шийтгэл ногдуулах арга хэмжээ авахаар тусгагдсан. Журам батлагдмагц аймгийн цахим хуудсанд байршуулах, журмын дагуу үнэлсэн үнэлгээ, дүгнэлтийг мөн цахим хуудсанд мэдээлэхээр төлөвлөж байна.

39	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйндүрмийгаймгийн албан ёсны цахим сайт болон төрийн захиргааны байгууллагуудын мэдээллийн самбарт байршуулсан.	
40	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	Аймгийн Засаг даргын 2014 оны А/495, А/496 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллагууд болон сумдын нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлж дүгнэх журмыг батлан хэрэгжилтыг хангуулан ажиллаж байгаа ба захирамжийг аймгийн цахим хуудас, иргэний танхим, нийтийн номын санд олон нийтэд ил тод байдлаар байршуулсан. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам гэж батлаагүй	
41	Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангах;	Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллахын хүрээнд Дорноговь аймгийн www.dornogovi.gov.mn вэб хуудсанд аймгийн ИТХ-аар батлуулсан 2014 оны жилийн орлого, зарлагын төлөвлөгөө түүний сар улиралын хуваарь, орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалт, тусгай зориулалтын шилжүүлгийн зардлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ болон цаг үеийн байдалтай холбогдон гарсан мэдээллүүдийг тус тус байршуулсан. Мөн аймгийн төсвийн ил тод байдлын самбарт дээрх мэдээллүүдийг давхар байршуулж иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудад төсөв, санхүүтэй холбоотой мэдээллээр ханган ажиллаж байна.	
42	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж нээлттэй байлгах	2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аймгийн ИТХ-ын 2014 оны 07 сарын 30-ны өдрийн 5/02 дугаараар баталсан аймгийн 2014 оны орон нутгийн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолыг аймгийн цахим хуудас болон ил тод байдлын самбарт байршуулан ажиллалаа.	
43	Тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд / өөрчлөлт ороогүй бол/ мэдээлэх	Тухайн жилийн төсөв болон нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээллийг /ИТХ-ын 2014 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 5/02 тогтоол/ www.dornogovi.gov.mn аймгийн цахим хуудасны шлэн данс цонхонд хуулийн хугацаанд байршуулсан.	
44	Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээг цахим хуудас	Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн жинхэнэ албанд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, зааврын дагуу Төрийн албаны зөвлөлөөс тогтоосон жишгээр мэргэшлийн шалгалтанд орохоор бүртгүүлж байгаа иргэдээс	

	болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	6000 төгрөгийн хураамж авдаг. Төрийн албан хаагчийн мэргэшлийн шалгалт 2014 онд нэг удаа зохион байгуулагдсан ба нийт 198 иргэн бүртгүүлж 1188000 төгрөг төвлөрсөн. Үүнээс 560550 төгрөгийг шалгалтын үйл ажиллагаанд, 603200 төгрөгийг төрийн албаны салбар зөвлөлийн төлөвлөгөөт үйл ажиллагаанд зарцуулж, үлдэгдэл 24250 төгрөгийг орон нутгийн төсвийн орлогот төвлөрүүлэв.	
45	Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэнэ.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын мэдээллийг хавсралтаар хүргүүлэв. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллийн самбарт байршуулсан иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.	
46	Иргэд байгууллагад олгогдсон зөвшөөрлийн бүртгэл, түүнийг олгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, олгох журмыг ил тод нээлттэй болгох	Аймгийн Засаг даргын Тамгын газраас олгодог Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, боловсрол, эрүүл мэндийн салбарын чиглэлээр олгогдож буй тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг www.dornogovi.gov.mn хууль эрх зүйн цонхноос авах боломжтой. Тусгай зөвшөөрлийн бүртгэлийг Хөгжлийн бодлогын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс хариуцан ажиллаж байна.	
47	Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг иргэд, олон нийтэд мэдээлэх	2014 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах дэлгэрэнгүй төлөвлөгөөг “Өнөөгийн Дорноговь” сонинд нийтлүүлж, аймгийн www.procurement-dornogovi.mn болон www.dornogovi.gov.mn , www.facebook.com/dornogobi.procurement цахим хуудсууд, байгууллагын мэдээллийн самбарт байршуулж иргэд олон нийтэд мэдээлсэн.	
48	Төрийн худалдан авах ажиллагааны жишиг баримт бичиг, сонгон шалгаруулалтын журам, урилгыг цахим хуудаст байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр нийтэд сурталчлах	Төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний тендерийн урилгыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn цахим хуудсанд тухай бүр байршуулж, нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг “Зууны мэдээ” сонинд зарлагдсан өдөрт нь нийтэлж байна. Мөн байгууллагын мэдээллийн самбар, www.procurement-dornogovi.mn , www.facebook.com/dornogobi.procurement цахим хуудсуудад байршуулан, орон нутгийн FM 101,5 болон 104,5 радио, DSB, MNT телевизүүдээр давхар нэвтрүүлж байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, журам заавар, жишиг баримт бичгийг байгууллагын www.procurement-dornogovi.mn цахим хуудсанд байршуулж нийтэд сурталчилж байна.	
49	Төсвийн орлого бүрдүүлэлт /татварын болон татварын бус орлогын талаарх/-ийн мэдээллийг нээлттэй байлгах	Дорноговь аймгийн www.dornogovi.gov.mn вэб хуудсанд аймгийн ИТХ-аар батлагдсан орон нутгийн 2014 оны татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн сарын мэдээг тус тус байршуулсан. Мөн аймгийн төсвийн ил тод байдлын самбарт төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр тогтмол байршуулсан.	

Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, энэ тухай цахим хуудсандаа байрлуулах болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлэх

Тендер шалгаруулалтын үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn, цахим хуудас болон аймгийн www.dornogovi.gov.mn, www.procurement-dornogovi.mn, www.facebook.com/dornogobi.procurement цахим хуудсууд, байгууллагын мэдээллийн самбарт байршуулж байна.

Аймгийн Ди Эс Би телевизийн "Нээлттэй цаг" шууд ярилцлагын нэвтрүүлэгт 2014 оны 2, 4, 8 дугаар саруудад /улирал бүр/ тус албаны дарга А.Энхжаргал, ахлах мэргэжилтэн Э.Мөнх-Оргил, Мерси кор ОУБ-ийн Зүүн бүсийн зохицуулагч Н.Хонгорзул нар оролцож, 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлуудын талаар болон худалдан авалтын тухай тайлан, 2014 оны худалдан авалтын төлөвлөгөө, хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийж, иргэдийн сонирхсон асуултанд шууд утсаар хариулт өгч ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Мерси кор ОУБ-тай хамтран 2014 оны 3,4 дүгээр сард “Хууль дүрэм бодит амьдралд-ил тод төрийн худалдан авах ажиллагаа” аян зарлав. Аяны хүрээнд “Хамгийн хамгийн”, төрийн худалдан авалтын ил тод нээлттэй байдлыг хангах, хуулийг сурталчилах иргэдийн нээлттэй хэлэлцүүлэг, сургалтуудыг зохион байгууллаа.

2014 оны 4-р сарын 8-ны өдөр Дорноговь аймгийн Худалдан Авах ажиллагааны албанаас Мерси Кор олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан “Шилэн Тендер” арга хэмжээ амжилттай боллоо.

Уг арга хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Тээвэр, авто замын газар, Аудитын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл, ИНБ-уудын төлөөлөл болон иргэдийн төлөөлөл зэрэг 70 гаруй хүмүүс оролцлоо.

Арга хэмжээний үеэр аймгийн Худалдан авах ажиллагааны алба, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Тээвэр, автозамын газраас 2013 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүн, шударга ил тод байдал, цахим тендер, гүйцэтгэл, хяналтын талаарх мэдээллийг хийж, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн худалдан авах ажиллагаан дахь оролцоо, хяналтыг дээшлүүлэх, тендерийн үнэлгээ, шалгаруулалт, гүйцэтгэлийн асуудлаар мэдээлэл, санал солилцож, ил тод байдлыг дээшлүүлэх арга замыг тодорхойлсон олон санал, асуултуудыг иргэдийн төлөөлөл болон хувийн хэвшлийн байгууллагуудаас авч, холбогдох албан байгууллагууд нь хариулт өгсөн үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Аймгийн Худалдан авах ажиллагааны алба, Мерси кор ОУБайгууллагатай хамтран "Шилэн тендер" арга хэмжээг Замын-Үүд суман 04 дүгээр сарын 14-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнд Замын-Үүд сумын ЗДТГазар, ЗААлба, МХАлба, ТББайгууллагууд, хувийн хэвшил, иргэдийн төлөөллүүд оролцож, аймгийн болон Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтын худалдан авах

		ажиллагааны хэрэгжилт, явц, үр дүн, иргэдийн оролцоо, ил тод, нээлттэй байдлын талаар мэдээлэл солилцож, иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгөв.	
51	Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	Төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний тендерийн урилгыг шалгуур үзүүлэлтүүдийн хамт Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn цахим хуудсанд тухай бүр байршуулж, нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг “Зууны мэдээ” сонинд зарлагдсан өдөрт нь нийтэлж байна. Мөн байгууллагын мэдээллийн самбар, www.procurement-dornogovi.mn , www.facebook.com/dornogobi.procurement цахим хуудсуудад байршуулан, орон нутгийн фм 101,5 болон 104,5 радио, DSB, MNT телевизүүдээр давхар нэвтрүүлж байна.	
52	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан шинэчлэх, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулах	Тендер шалгаруулалтын үр дүн, шалгарсан болон татгалзсан үндэслэлийг дэлгэрэнгүйгээр аймгийн www.dornogovi.gov.mn , байгууллагын www.procurement-dornogovi.mn , www.facebook.com/dornogobi.procurement цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүрт нь байршуулж нийтэд мэдээлж байна.	
53	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулах	Худалдан авалтын явцын тайлан, мэдээг байгууллагын мэдээллийн самбар, www.procurement-dornogovi.mn , www.facebook.com/dornogobi.procurement цахим хуудсуудад байршуулан, орон нутгийн “Өнөөгийн Дорноговь” сонины 2014 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 04/23/ дугаарт нийтлүүлж иргэдэд мэдээлэв.	
54	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх	Тендер шалгаруулалтын явцад илэрсэн зөрчлийн тохиолдол гараагүй.	
55	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	2012 оныхудалдан авах ажиллагаанд хийсэн Аудитын дүгнэлтийг мэдээллийн самбарт байршуулж нийтэд мэдээлсэн. 2013 оны Аудын дүгнэлт гараагүй байна.	
56	Тухайн жилд явуулах хяналт шалгалтын жилийн ажлыг төлөвлөсөн байх	Сумдын Засаг дарга түүний Тамгын газар, төсвийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх баг аймгийн Засаг даргын Тамгын газраас жилд 2 удаа /хавар, намар/ ажилладаг. Аймгийн Засаг даргын 2014 оны А/152, А/485 дугаар захирамжаар тусгай удирдамж, төлөвлөгөө батлан 4 чиглэлд 5 дугаар сарын 12-23, 10 дугаар сарын 13-25-ны хооронд тус тус ажиллалаа. Шалгатын удирдамжийг сумдын Засаг даргын Тамгын газарт 8-10 хоногийн өмнө хүргүүлж, удирдамжийн дагуу чиглэл тус бүрт 9-11 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан ба хяналт шинжилгээ хийсэн тайланг нэгтгэж Засаг даргын зөвлөлийн хурлаар	

		<p>хэлэлцэж хяналт шинжилгээ үнэлгээгээр хангалтгүй байсан, ажлын хариуцлага алдсан зарим сум, байгууллагад ажлын хариуцлага сайжруулах үүрэг чиглэл өгч ажиллаж байна.</p> <p>Мөн аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний тасгаас Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын 2014 оны А/438 дугаар захирамжаар баталсан ажлын хэсэг Худалдан авах ажиллагааны албаны 2014 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд дотоод аудит хийлээ. Дотоод аудит хийсэн ажлын хэсгийн дүгнэлт болон холбогдох баримтуудыг Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, “Бизнес инкубатор төв”-ийн үйл ажиллагаанд 09 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд дотоод хяналт шалгалт зохион байгууллаа. Дээрх хугацаанд “Бизнес инкубатор төв”-ийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, санхүүгийн материал, сургалт, үзэсгэлэн, бойжигчдын анхан шатны материалууд, бойжигчдын үйл ажиллагаа, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт, Хөдөлмөрийн хэлтэсээс “Бизнес инкубатор төв”-ийг удирдлага зохион байгуулалтаар хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар хяналт шалгалт зохион байгуулж, дүгнэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулж ажил сайжруулах чиглэлээр албан даалгавар хүргүүллээ.</p> <p>Төрийн сангийн дотоод хяналтын мэргэжилтэнг 2014 оны 5 сарын 1-ний өдрөөс томилон ажиллуулж сумдын төрийн сан түүний үйл ажиллагааны эрсдлийг үнэлүүлэн 2014 онд хийгдэх сумдын төрийн сангуудын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөнд нийт 14 сумын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөний дагуу 10 суманд хэрэгжүүлэн гүйцэтгэлээр 71,5 хувьтай байна.</p>	
57	Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээг ил тод болгох /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах/	<p>Сумдын Засаг дарга түүний Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн шалгалтаар хангалтгүй байсан сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга болон холбогдох албан тушаалтан, зарим агентлаг, төсвийн байгууллагын дарга эрхлэгч нарыг оролцуулсан “Хэрэгжилт-хяналт-хариуцлага” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг 11 дүгээр сарын 08-нд зохион байгуулахаар төлөвлөж байна. Уг нээлттэй хэлэлцүүлэг зөвлөгөөнөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээгээр илэрсэн төрийн байгууллага, албан тушаалтны ажлын хариуцлагагүй байдал, мэдлэг чадвар, ёс зүйн доголдол зөрчлийг иргэдэд нээлттэйгээр хэлэлцүүлэн, хариуцлагагүй хандсан төрийн албан хаагчдад хариуцлага тооцож, алдаа дутагдлыг залруулах арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөж байна.</p> <p>Сумдын төрийн сан түүний үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх 2014 оны төлөвлөгөөний дагуу Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд, Мандах, Сайншанд сумдад Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын баталсан удирдамжийн хүрээнд төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллалаа. Хяналтаар</p>	

		<p>илэрсэн алдаа дутагдлыг холбогдох албан тушаалтанд газар дээр нь заавар зөвлөгөөг өгч аймгийн Засаг даргын 2/1005, 3/1016 тоот зөвлөмжийг хүргүүлээд байна.</p> <p>Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс, Бизнес Инкубатор Төвд, Сангийн сайдын удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар Худалдан авах ажиллагааны албанд тус тус дотоод аудитыг хийж илэрсэн зөрчил дутагдлыг хэрхэн арилгах талаар заавар зөвлөгөө болон холбогдох албан тушаалтанг хариуцлагажуулах аймгийн Засаг даргын 1/1173 тоот зөвлөмж, Сангийн яаманд 3/1321 тоот дүгнэлтийг тус тус хүргүүлсэн.</p>	
58	<p>Гомдол, мэдээлэл хүлээн авах чиг үүргийг бүтцийн нэгж /ажилтанд/-д хариуцуулж, тухайн ажилтны овог, нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийн хүлээн авах цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах болон нийтэд бусад хэлбэрээр мэдээлэх</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын орон тоонд Иргэдтэй харилцах асуудал хариуцсан бие даасан мэргэжилтэн томилон ажиллуулж иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч удирдлагад мэдээлэн тухай бүр шийдвэрлүүлж ажиллаж байна. Тухайн ажилтны овог, нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийн хүлээн авах цагийн хуваарийг аймгийн цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.</p>	
59	<p>Иргэдийн санал, хүсэлт, гомдол, мэдээлэл хүлээн авах тусгай дугаарын утас ажиллуулах, цахим болон санал хүсэлтийн хайрцаг, бичгээр, мөн биечлэн хүлээн авах боломжийг бүрдүүлэх, бүртгэл хөтлөх</p>	<p>Аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах, үр дүнг тооцох, аймгаас гаргах бодлого, шийдвэрт иргэдийн санал бодлыг тусгах, нээлттэй, шуурхай, ил тод байдлыг бүрдүүлэх зорилгоор Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээний шинэ менежмент нэвтрүүлэх тухай журмыг боловсруулан аймгийн Засаг даргын 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/504 тоот Захирамжаар батлуулсан.</p> <p>Дээрх журамд иргэдийн санал, хүсэлт, гомдол, мэдээллийг авах утас нь аймгийн Засаг даргын Тамгын газрын “Нэг цонхны үйлчилгээ”-ний төв дээр 70520003 тоот тусгай дугаарын утсыг ажиллуулж эхлээд байна. Мөн eoffice.70520003.mn E-Cloud байгууллагын мэдээлэл солилцооны цахим систем, www.70520003.mn Иргэдийн өргөдөл, гомдол санал хүсэлт бүртгэх, түүний шийдвэрлэлтэд хяналт тавих цахим систем тус тус нэвтрүүлээд байна. Дээрх программыг бүх сумдын Засаг даргын Тамгын газар болон аймгийн агентлаг, байгууллагуудад нэвтрүүлэхээр эхний ээлжийн сургалтыг зохион байгуулаад байна. Нээлттэй утсаар 7 иргэний гомдол ирүүлснийг хүлээн авч, холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.</p>	
60	<p>Иргэдийн санал, хүсэлт, гомдол, мэдээллийг шуурхай хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэх, хариуг албан ёсоор мэдэгдэх</p>	<p>Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт хандаж 2014 оны 3 дугаар улирлын байдлаар 61-н өргөдөл ирсний 53 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд судлагдах шатандаа явагдаж байгаа 8-н өргөдөл байна. Мөн иргэдээс нутгийн захиргааны байгууллагад хандан 2223 өргөдөл, гомдол ирүүлснийг судлан үзэж 2142</p>	

		өргөдлийг зохих журмын дагуу шийдвэрлэж хариу өгсөн бөгөөд шийдвэрлэх хуулийн хугацаа болоогүй 81-н өргөдөл судлагдаж байна.	
Дөрөв. Хяналт шинжилгээ, үнэлгээ			
61	Авлигын эсрэг хуулиар хүлээсэн үүргийн талаарх тайланг АТГ-т хүргүүлэх	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж болон судалгааг холбогдох албан хаагчдаас авч нэгтгэн албан тоотод дурьдагдсан хугацаанд хүргүүлж ажиллсан.	
62	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргаж АТГ-т хүргүүлэх	Үндэсний хөтөлбөр дээд шатны байгууллагаас батлагдаж ирээгүй тул тайлан мэдээ гарах болмжгүй байна.	
63	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн дүнг АТГ-т хүргүүлэх.	2014 оны авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг гаргаж аймгийн Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 1/1664 дугаар албан бичгээр хүргүүлж байна.	
64	Үндэсний хөтөлбөр болон төлөвлөгөөний хэрэгжилтэд байнгын мониторинг хийж үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах	Төлөвлөгөөний хэрэгжилт болон Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.	

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАН-ОТГОН